

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Идэр сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2022/13/СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 70463612 Цахим хаяг: batundraa@audit.gov.mn Ахлах аудитор : Б.Дагвасүрэн Утас:99014227 Цахим хаяг:dagvasurenb@audit.gov.mn Аудитор П.Ганцолмон Утас:70157405 Цахим хаяг:uliastaivanaudit@ubaudit.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал, Шилэн дансны хуулийн хэрэгжилт, бусад хууль тогтоомж	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1. Төрийн аудитын санал, дүгнэлт


**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

ИДЭР СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА М.ПҮРЭВЖҮГДЭР-Т

№ 1302/2021
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Идэр сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Идэр сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

30.0 сая төгрөгийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан, 30.2 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг бүрдүүлээгүй зэрэг нь (Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4; 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна)

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Давсны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	18,366,328.50	49,087,428.50
33	АВЛАГА	-	30,000,000.00
335	Бусад авлага	-	30,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	30,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	18,366,328.50	19,087,428.50
354	Хангамжийн материал	10,756,328.50	11,477,428.50
35410	Бичиг хэргийн материал	1,090,700.00	1,156,800.00
35420	Аж ахуйн материал	8,833,815.00	9,488,815.00
35470	Бусад хангамжийн материал	831,813.50	831,813.50
35600	Мал амьтад	7,610,000.00	7,610,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	600,165,472.88	623,883,856.28
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	600,165,472.88	623,883,856.28
392	Биег хөрөнгө	594,519,472.88	618,567,856.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	616,810,755.24	591,952,165.24
39202	Хуримтлагдсан элэгдэл	(131,536,059.01)	(133,244,524.13)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	123,254,800.00	176,554,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(67,520,733.24)	(74,583,199.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	160,310,071.00	174,394,071.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(147,183,489.35)	(151,496,342.79)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,889,800.00	31,889,800.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(23,237,380.68)	(25,351,084.80)
39214	Бусад үндсэн хөрөнгө	51,137,394.00	51,137,394.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(20,422,665.08)	(23,702,202.44)
39217	Ном	1,016,980.00	1,016,980.00
393	Биег бус хөрөнгө	5,646,000.00	5,316,000.00
39301	Програм хангамж	3,172,000.00	3,172,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,522,000.00)	(1,852,000.00)
39303	Бусад биег бус хөрөнгө	3,996,000.00	3,996,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	618,531,801.38	672,971,284.78
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	618,531,801.38	672,971,284.78
51	Засгийн газрын хувь оролцоо	618,531,801.38	672,971,284.78
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	696,313,921.20	696,313,921.20
51101	Өмч: - төрийн	696,313,921.20	696,313,921.20
512	Хуримтлагдсан үр дүн	(94,387,262.25)	(32,995,343.35)
51210	Өмнөх үеийн үр дүн	(42,144,909.29)	(87,434,826.75)
51220	Тайлант үеийн үр дүн	(52,242,352.96)	54,439,483.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	16,605,142.43	9,652,706.93
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	618,531,801.38	672,971,284.78

2.2 Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	297,394,317.00	436,509,826.00
12	ТАТВАРЫН БҮС ОРЛОГО	4,602,520.00	55,805,000.00
120	Нийтлэг татварын бүс орлого	4,602,520.00	55,805,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,602,520.00	55,805,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,602,520.00	55,805,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	292,791,797.00	380,704,826.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	260,038,600.00	361,844,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	260,038,600.00	361,844,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,153,197.00	18,860,126.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,153,197.00	18,860,126.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,600,000.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,600,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	349,636,669.96	382,070,342.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	349,636,669.96	382,070,342.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	338,345,169.96	364,341,242.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	192,668,400.00	196,868,400.00
210101	Үндсэн цалин	191,353,034.00	196,868,400.00
210102	Нэмэгдэл	1,315,366.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,010,300.00	26,010,300.00
210201	Тэтгэврийн даатгал	18,780,719.00	18,303,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,713,517.00	1,926,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,520,637.00	1,541,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	363,216.00	385,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,632,211.00	3,853,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,601,900.00	22,601,900.00
210301	Гэрэл, цахилгаан	2,000,300.00	2,000,000.00
210302	Түлш, халаалт	20,601,600.00	20,601,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,476,775.00	18,366,800.00
210401	Бичиг хэрэг	2,306,800.00	2,509,900.00
210402	Тээвэр, шатахуун	12,309,650.00	12,999,600.00
210403	Шүүдэн, холбоо, интернэтийн төлбөр	3,048,700.00	2,857,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	811,625.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,882,000.00	1,344,100.00
210604	Урсгал засвар	4,882,000.00	1,344,100.00
2107	Томилголт, зочны зардал	3,390,300.00	3,291,700.00
210702	Дотоод албан томилолт	3,390,300.00	3,291,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,933,647.00	25,128,226.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,577,547.00	23,768,126.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232,100.00	232,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	448,850.00	469,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700.00	227,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	94,050.00	73,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	353,400.00	203,400.00
210807	Газрын төлбөр	-	138,300.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	15,700.00

Идэр сумын Засаг дарын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,381,847.96	70,729,816.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,500,000.00	26,760,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303,400.00	303,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	58,578,447.96	43,665,616.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,291,500.00	17,729,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	16,947,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	16,947,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,291,500.00	781,500.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,291,500.00	781,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(52,242,352.96)	54,439,483.40
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(52,242,352.96)	54,439,483.40

2.3 Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	696,313,921.20	16,605,142.43	(42,144,909.29)	670,774,154.34
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	696,313,921.20	16,605,142.43	(42,144,909.29)	670,774,154.34
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олъ, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(52,242,352.96)	(52,242,352.96)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	696,313,921.20	16,605,142.43	(94,387,262.25)	618,531,801.38
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	696,313,921.20	16,605,142.43	(94,387,262.25)	618,531,801.38
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	696,313,921.20	16,605,142.43	(94,387,262.25)	618,531,801.38
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олъ, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	54,439,483.40	54,439,483.40
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	696,313,921.20	16,605,142.43	(39,947,778.85)	672,971,284.78

2.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	292,791,797.00	380,704,826.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	292,791,797.00	380,704,826.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	260,038,600.00	361,844,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	260,038,600.00	361,844,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,153,197.00	18,860,126.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,153,197.00	18,860,126.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,600,000.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	29,600,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	291,141,797.00	368,620,826.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	291,141,797.00	368,620,826.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	279,850,297.00	350,891,726.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшилт	192,868,400.00	196,868,400.00
210101	Үндсэн цалин	191,353,034.00	196,868,400.00
210102	Нэмэгдэл	1,315,366.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,010,300.00	26,010,300.00
210201	Тэтгэврийн даатгал	18,303,500.00	18,303,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,926,700.00	1,926,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,541,300.00	1,541,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	385,400.00	385,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,853,400.00	3,853,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,601,900.00	22,601,900.00
210301	Гэрэл, цахилгаан	2,000,300.00	2,000,000.00
210302	Түлш, халаалт	20,601,600.00	20,601,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,934,350.00	18,258,700.00
210401	Бичиг хэрэг	2,576,000.00	2,576,000.00
210402	Тээвэр, шатахуун	12,309,650.00	12,634,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,048,700.00	3,048,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,508,000.00	31,344,100.00
210604	Урсгал засвар	5,508,000.00	31,344,100.00
2107	Томилголт, зочны зардал	3,390,300.00	3,291,700.00
210702	Дотоод албан томилголт	3,390,300.00	3,291,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,933,647.00	25,128,226.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,577,547.00	23,768,126.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232,100.00	232,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	469,100.00	469,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700.00	227,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73,800.00	73,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	353,400.00	203,400.00
210807	Газрын төлбөр	-	138,300.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	15,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,803,400.00	27,388,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,500,000.00	27,085,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303,400.00	303,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,291,500.00	17,729,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	16,947,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	16,947,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,291,500.00	781,500.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,291,500.00	781,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,650,000.00	12,084,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,650,000.00	12,084,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,650,000.00	12,084,000.00
2200	Дотоод эхүүсвэрээр	1,650,000.00	12,084,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,650,000.00	12,084,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,650,000.00)	(12,084,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	328,265,200.00	328,265,200.00	-	100%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	328,265,200.00	328,265,200.00	-	100%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	311,317,600.00	311,317,600.00	-	100%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	196,868,400.00	196,868,400.00	-	100%
210101	Үндсэн цалин	196,868,400.00	196,868,400.00	-	100%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,010,300.00	26,010,300.00	-	100%
210201	Тэтгэврийн даатгал	18,303,500.00	18,303,500.00	-	100%
210202	Тэтгэмжийн даатгал	1,926,700.00	1,926,700.00	-	100%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,541,300.00	1,541,300.00	-	100%
210204	Ажилгүйдлийн даатгал	385,400.00	385,400.00	-	100%
210205	Эрүүл мэндийн даатгал	3,853,400.00	3,853,400.00	-	100%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,601,900.00	22,601,900.00	-	100%
210301	Гэрэл, пахилгаан	2,000,000.00	2,000,000.00	-	100%
210302	Түлш, халаалт	20,601,900.00	20,601,900.00	-	100%
2104	Хангамж, бараа материалын зардал	24,758,700.00	24,758,700.00	-	100%
210401	Бичиг хэрэг	2,576,000.00	2,608,100.00	(32,100.00)	101%
210402	Тээвэр, шатахуун	12,134,000.00	12,134,000.00	-	100%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,048,700.00	3,048,700.00	-	100%
210406	Бага үнэтэй, тургэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,000,000.00	6,967,900.00	32,100.00	100%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,344,100.00	1,344,100.00	-	100%
210604	Урсгал засвар	1,344,100.00	1,344,100.00	-	100%
2107	Томиллолт, зочны зардал	3,291,700.00	3,291,700.00	-	100%
210702	Дотоод албан томиллолт	3,291,700.00	3,291,700.00	-	100%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,970,100.00	8,970,100.00	-	100%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,610,000.00	7,610,000.00	-	100%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232,100.00	232,100.00	-	100%
210803	Даатгалын үйлчилгээ	469,100.00	469,100.00	-	100%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700.00	227,700.00	-	100%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73,800.00	73,800.00	-	100%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203,400.00	203,400.00	-	100%
210807	Газрын төлбөр	138,300.00	138,300.00	-	100%
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15,700.00	15,700.00	-	100%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,472,400.00	27,472,400.00	-	100%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,169,000.00	27,169,000.00	-	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303,400.00	303,400.00	-	100%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,947,600.00	16,947,600.00	-	100%
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,947,600.00	16,947,600.00	-	100%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,947,600.00	16,947,600.00	-	100%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,346,800.00	328,265,200.00		100%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	8,346,800.00	328,265,200.00		100%
122005	Орон нутгийн төсвөөс	8,346,800.00	328,265,200.00		100%

2.6 Аудит хийсэн Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	51,658,126.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	51,658,126.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	51,658,126.00
2104	Хангамж, бараа материалын зардал	500,000.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00
2106	Эд хөгшил, урсгал засварын зардал	30,000,000.00
210604	Урсгал засвар	30,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,158,126.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,158,126.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	781,500.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	781,500.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	18,860,126.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,860,126.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,860,126.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Идэр сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Улиастай ван аудит ХХК-ийн ахлах аудитор П.Ганцолмон, аудитор Д.Гэрэлхүү нар гүйцэтгэж, ахлах аудитор Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Идэр сумын ЗДТГ-т 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 21-ны өдрийн 03/22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Идэр сумын ЗДТГ нь сумын Засаг даргын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын туслалцаа үзүүлж, ажиллах нөхцөл бололцоогоор хангахын зэрэгцээ цаг үеэ олсон, мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэгээр шуурхай хангах замаар хууль тогтоомж, бусад эрх зүйн хэм хэмжээний акт, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг сумын нутаг дэвсгэрт бүрэн дүүрэн хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг бүхий ажлын алба юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна. Идэр сумын ЗДТГ нь дотоод аудитын нэгж байхгүй.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино. Өмнө Идэр сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны эхний хагас жилийн нийт орлого 267,370.3 мянган төгрөгийн 1 хувиар буюу 2,673.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1,871.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлого 436,509.8 мянган төгрөгийн 1 хувь буюу 4,365.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг түүний 70 хувь буюу 3,055.6 мянган төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага		30,000.0	30,000.0
Бараа	18,366.3	19,087.5	721.2
Үндсэн хөрөнгө	600,165.5	623,883.7	23,718.2
Нийт хөрөнгө	618,531.8	672,971.2	54,439.4
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	618,531.8	672,971.2	54,439.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө	618,531.8	672,971.2	54,439.4

Авлага дансны үлдэгдэл 30,000.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь зориулалт бус зарцуулалттай холбоотой байна.

Бараа материалын данс 721.1 мянган төгрөгөөр өссөн нь бараа материалын худалдан авалттай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 23,781.1 мянган төгрөг болж өссөн нь тайлант онд хандив тусламжаар ОБЕГ-ын харьяа 185-р ангиас УАЗ хантер маркийн авто машиныг 45,000.0 мянган төгрөгөөр, иргэн Н.Төрмөнхөөс Зил 130 авто машиныг 8,390.0 мянган төгрөгөөр авч, 24,858.6 мянган төгрөгийн хуучин барилгыг данснаас хассан зэрэгтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 54,439.4 мянган төгрөг болж өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 328,265.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж батлуулсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 328,265.2 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, урсгал үйл ажиллагаанд 328,265.2 мянган төгрөгийг зарцуулжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 52,439.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэн, 51,658.1 мянган төгрөгийг зарцуулан, үлдэгдэл 781.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Нягтлан бодогч нь худалдан авалт хийхдээ и баримтыг бүрэн бүрдүүлээгүй байна.

3.9 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 148 мэдээллээс 144 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон мэдээлэл 4 байна.

Хугацаа хоцроосон 4 мэдээлэл нь Нийтийн ашиг сонирхол, хувийн ашиг сонирхлыг зохицуулах тухай, бонд, өрийн бичиг баталгаа, төвлөрүүлэх орлогын тайлан мэдээлэл байна. Байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Зардлыг зориулалтын дагуу зарцуулж, сумын ОНХС-ийн санхүүжилтийг ЗДТГ-ын үйл ажиллагааны зардлаас салган тайлагнаж хэвших шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 60,200.0 мянган төгрөгийн зөрчлийг илрүүлэн, 30,000 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон 30,200.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

4.1 Залруулсан алдаа байхгүй.

4.2 Төлбөрийн акт

- ✓ Илрүүлэлт: Тус сумын ЗДТГ нь Баян тэгш Баяжих ХХК -д 2021 оны 12 сарын 23-ны өдрийн 02 тоот зарлагын гүйлгээгээр 30,000.0 мянган төгрөгийг урсгал засварын зардал нэрээр шилжүүлж авлага үүсгэсэн байгааг зориулалт бус зарцуулалт гэж үзэн төлбөрийн акт тогтоолоо. Баяр наадмын т албайг засварлах ажлын тендерийг тайлант оны 11 дүгээр сард зохион байгуулан, санхүүжилтийг 100 хувь ажлын гүйцэтгэл гараагүй байхад олгосон нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан” Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам” -ыг зөрчсөн байна.

4.3 Албан шаардлага байхгүй.

4.4 Зөвлөмж:

1. Татвартай холбоотой асуудал

- ✓ Илрүүлэлт: Тайлант хугацаанд 114,692.2 мянган төгрөгийн худалдан авалт хийснийг и баримтын цахим бүртгэлтэй тулгахад 30,213.9 мянган төгрөгийн гүйлгээ нь и баримтгүй байгаа нь нотлогдлоо.
- ✓ Өгсөн зөвлөмж: И баримтыг бүрдүүлээгүй зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл,

мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ." Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Идэр сумын ЗДТГ	2	60.2	-	-	1	30.0	-	-	1	30.2